

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийхуудас 2018 оны 1 сарын дугаар

Тэргүүн мэдээ.

Өвсний үндэс Техникийн Хамтын Ажиллагаа “Монгол хүүхдүүдийн шүдний цоорлоос урьдчилан сэргийлэх төсөл”-ийн хүрээнд амны хөндийн үзлэг хийв.



Үзлэг оношилгооны явцтай танилцаж буй Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл

Өвсний үндэс ТХА-ны “Монгол хүүхдүүдийн шүдний цоорлоос урьдчилан сэргийлэх төсөл”-ийн хүрээнд Токушима Монголын эрүүл мэндийн хамтын ажиллагааны нийгэмлэг болон Монголын шүдний эмч нарын холбоо хамтран 2017 оны 10 дугаар сараас эхлэн 2 жилийн хугацаанд цэцэрлэгийн насны хүүхдийн шүдэнд үзлэг оношилгоо хийх, энэ талын боловсролын системийг төлөвшүүлэх, шүд цоорох өвчлөлийн хувийг бууруулах зорилгоор Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 18-р хороонд үйл ажиллагаа явуулж байна. Монголд сүүлийн жилүүдэд хүүхдийн шүд цоорох өвчнийг бууруулахаар ЭМЯ-наас хүүхдийн амны хөндийн эрүүл ахуйг хамгаалах арга хэмжээнд онцгой анхаарал хандуулж байгаа юм. 1 дүгээр сарын 8-аас 10-ны өдрүүдэд тус дүүргийн эрүүл мэндийн төв болон цэцэрлэг дээр энэхүү төслийн Япон мэргэжилтнүүд Монгол эмч нарын хамт амны хөндийн үзлэг хийсэн бөгөөд уг арга хэмжээтэй ирж танилцсан Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл төслийн үйл ажиллагааг өндрөөр үнэлэхийн зэрэгцээ цаашид амны хөндийн эрүүл ахуйг хамгаалах арга хэмжээг тууштай авч хэрэгжүүлэхээ илэрхийлэв.

Улс төрийн, эдийн засгийн чиг хандлага

Агаарын тухай хуулийг шинэчлэн батлав.



Агаарын бохирдолтой Улаанбаатар хот

Улаанбаатар хотод өвлийн улиралд гэр хорооллын нүүрсний утаа болон автомашинаас ялгарах хаягдал хийн улмаас агаарын бохирдол дээд цэгтээ хүрдэг. PM2.5, PM10 тоосонцор, хүхрийн хий (Sox), азотын хий (Nox) зэрэг агаар бохирдуулагч бодисын нягтрал нь монгол улс болон ДЭМБ-ын байгаль орчны стандартаас хэд дахин давж, ард иргэдийн эрүүл мэндэд хохирол учруулж байгаа нь санаа зовоосон асуудал болоод байна. Ийм нөхцөл байдалд УИХ 1 сарын 12-ны өдөр Агаарын тухай хууль болон холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэн баталлаа. Энэ удаагийн нэмэлт өөрчлөлтөд агаарын бохирдлыг бууруулах сан байгуулах, уг сангийн хөрөнгийг ашиглан сайжруулсан түлшний технологи, үйлдвэрлэлийг санхүүжүүлэх, барилга байгууламжийн дулаалгыг сайжруулах, төвлөрсөн дулаан хангамжийн дэд бүтцийг байгуулахаас гадна цахилгаан халаагуурыг татвараас чөлөөлөх зэрэг арга хэмжээг тусгасан байна. Иргэд агаарын бохирдлын эсрэг үр нөлөөтэй арга хэмжээ авахыг шаардан жагсаал цуглаан хийж буй энэ үед засгийн газар болон Улаанбаатар хот бодит үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлж чадах эсэх нь анхаарал татаж байна.

Төслийн хэрэгжилт

“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын хүний нөөц, ашиглалт, менежментийн чадавхийг сайжруулах төсөл”-ийн Хамтарсан зохицуулах хорооны 5-р хурал хуралдав.




Хамтарсан зохицуулах хорооны хурал

2018 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын хүний нөөц, ашиглалт, менежментийн чадавхийг сайжруулах Техникийн хамтын ажиллагааны төсөл”-ийн Хамтарсан зохицуулах хорооны 5-р хурал (JCM) хуралдав. Монгол Улсад иений хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг барьж байгаа бөгөөд энэхүү төслийн хүрээнд нисэх буудлыг саадгүй нүүлгэн шилжүүлэх, үйл ажиллагааг нь эхлүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. Энэ удаагийн Хамтарсан зохицуулах хорооны хуралд Зам тээврийн хөгжлийн яам,

ИНЕГ зэрэг Монгол талын төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон ЖАЙКА-ийн мэргэжилтнүүд оролцож нисэх буудлын үйл ажиллагаагэхлүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал, албадын үйл ажиллагааны заавар (төсөл) зэрэг өнөөг хүртэл хийгдсэн ажлын үр дүнг тодруулахын зэрэгцээ нисэх буудлын ашиглалттай холбоотой асуудлууд, төслийн цаашдын үйлэх буудлын ашиглалттай холбоотой асуудлууд,в. Цаашид Монгол, Япон талын холбогдох хүмүүс нисэх буудлын ашиглалтыг яаралтай эхлүүлэх талаар хүчин чармайлт гарган хамтран ажиллахаар болов.

Монгол,Японы хүний нөөцийн хөгжлийн төв дээр“ЕРА-г хэрхэн үр дүнтэй ашиглах вэ” сэдэвт сургалт зохион байгуулав.



Сургалтын байдал

2016 оны 6 сард Монгол,Японы эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болсонтой холбоотойгоор ТХА “Монгол Японы хүний нөөцийн хөгжлийн төв-Бизнесийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, хамтын ажиллагааны суурийг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд тус төвийн бизнесийн сургалт дээр “ЕРА-ийг хэрхэн үр дүнтэй ашиглах вэ”сэдэвт сургалтыг оруулсан. 1 сарын 15-19-нд зохион байгуулсан уг сургалт дээр Японы эдийн засгийн их сургуулийн профессор Томита Кожи эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн ач холбогдол, бизнес хөгжүүлэх боломжийн талаар лекц уншсанаас гадна МХАҮТ-аас гарал үүслийн гэрчилгээ олгох процедурын талаар танилцуулга хийж, “Азума шиппинг монголиа” ХХК-ийн зүгээс Монгол,Японы хоорондох тээврийн асуудлын талаар мэдээлэл өгч, Японы зах зээлд бүтээгдэхүүнээ экспортлохоор төлөвлөж буй Монголын хувийн хэвшлийн ААН-үүд, ХХААХҮЯ-ны ажилтнууд зэрэг оролцогчдын талархалыг хүлээсэн сургалт болов.

“Хүлэмжийн хийн тооллого хийх чадавхийг бэхжүүлэх замаар үндэсний хүлэмжийн хийн тооллогын мөчлөгийг тасралтгүй сайжруулах нь” төслийн Хамтарсан зохицуулах хорооны анхдугаар хуралдаан болов.



Хамтарсан зохицуулах хорооны анхдугаар хуралдаан

1 сарын 16-ны өдөр Монголын талаас БОАЖЯ болон Байгаль орчин уур амьсгалын сан хариуцан хэрэгжүүлж буй “Хүлэмжийн хийн тооллого хийх чадавхийг бэхжүүлэх замаар үндэсний хүлэмжийн хийн тооллогын мөчлөгийг тасралтгүй сайжруулах нь” төслийн Хамтарсан зохицуулах хорооны анхдугаар хуралдаан болов. Энэхүү төсөл нь монголын засгийн газрын уур амьсгалын өөрчлөлтийн талаарх арга хэмжээнд ач холбогдол өсч буй нөхцөл байдалд хүлэмжийн хийн тооллогын системийг бий болгох чадавхийг дээшлүүлэх зорилгоор хэрэгжиж байгаа юм. Хамтарсан зохицуулах хорооны хуралдаан дээр төслийн үр дүн, үйл ажиллагааны агуулгын талаар санал солилцож, холбогдох талууд үйл ажиллагааны төлөвлөгөөгөө тохиролцож монгол,япон хоёр тал хамтран ажиллаж хэрэгжүүлэх эрмэлзлээ нотлов. Мөн хамтарсан зохицуулах хорооны хуралдааны дараа энэхүү төслийн хэрэгжүүлэх байгууллагууд, донорууд, ТББ,судалгааны байгууллагууд оролцсон Workshop семинар болж, хүлэмжийн хийн талаар мэргэжлийн хэлэлцүүлэг хийж, санал солилцов.

Хичээлийн судалгааны нийгэмлэгийн онол практикийн 5-р бага хурал болов.



Хичээлийн судалгааны ач холбогчдыг тайлбарлаж буй МУБИС-ийн профессор Т.Ганбаатар

1 сарын 11,12-ны өдөр Хичээлийн судалгааны нийгэмлэгийн онол практикийн 5-р бага хурал Улаанбаатар хотод болов. Энэхүү нийгэмлэгийг 2013 он хүртэл хэрэгжсэн техникийн хамтын ажиллагааны “Заах аргыг сайжруулах нь” (“Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”) төслийн хүрээнд хичээлийн судалгааны үйл ажиллагаанд хамрагдсан багш нар сурсан мэдсэнээ бусад багш нартаа дамжуулах зорилгоор төсөл дууссаны дараа санаачлан байгуулсан юм. Бага хуралд оролцогчдын тоо жилээс жилд өсөж байгаа бөгөөд энэ жилийн 5-р бага хуралд 200 гаруй хүн оролцов. “Хичээлийн чанар судалгаанаас” уриан доор зохион байгуулагдсан уг бага хуралд 17 аймаг, нийслэлийн багш, боловсролын ажилтан нийт 54 хүн илтгэл тавив. МУБИС-ийн багш илтгэлдээ “Хичээлийн явцад хүүхдийн гадаад байдлаар нь тун бага юмыг тодорхойлж болно.Харин анализ, хичээлийн судалгаа хийснээр хүүхдийн ойлголтын түвшинг тодорхойлох боломжтой” хэмээн тэмдэглэж байгаагаас харахад төсөл бие даан өргөжиж байгаа дүр зураг ажиглагдаж байна.

Бусад төслийн хэрэгжилтийн байдал.

1 сарын 19-ний өдөр “Суралцахуйг дэмжих мэргэжлийн байгууллагыг чадавхжуулах” (Project Child centered Education Supports) төслийн урт хугацааны мэргэжилтэн Цукагоши нутаг буцав.

Сайн дурын үйл ажиллагаа

Сайн дурын үйл ажиллагааны танилцуулга. (Эрдэнэт хотод нөхөн сэргээх семинар зохион байгуулав.)



Семинарын байдал

12 сарын 7 болон 8-ний өдөр Эрдэнэт хотын Бүсийн оношлогоо, эмчилгээний төвд сайн дурын гишүүн Кавабата Миноругийн (2015 оны 4-р ээлжийн сувилагч) санаачлагаар нөхөн сэргээх семинар зохион байгуулагдлаа. Энэхүү семинарт Эрүүл мэндийн салбарт ажиллах сайн сурын холбооны хөдөлмөр засалч болон хөдөлгөөн засалч мөн хамтран ажиллах монгол эмч нарыг урьж оролцуулсан юм. Энэ жил 6 дугаар сараас хойш зохион байгуулагдаж буй 2 дахь семинар бөгөөд өмнөх семинараар олгосон нөхөн сэргээх анагаах ухааны үзэл баримтлал, суурь ойлголт дээр үндэслэн клиникийн нөхцөлд хэрэгжүүлж болохуйц харьцангуй практик агуулагатай болсон билээ. Семинарт оролцогчдийг багт хуваан хамтран ажиллагч монгол эмч нар нь удирдан бусад оролцогчдын ойлголтын байдлыг лавлангаа ур чадварын зааварчлагаа өгсөн бөгөөд оролцогчид ур чадвар эзэмших мэдлэгт хүчин чармайлт гарган идэвхтэй оролцсон юм. Цаашид ч энэ төрлийн семинараар дамжуулан эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээг үргэлжлүүлэн гүйцэтгэн хийх болно.

Сайн дурын бусад үйл ажиллагааны тухай мэдээ

• 1 сарын 10-ны өдөр 6 шинэ сайн дурын гишүүн хүрэлцэн ирэв.: Очиай Сатору (хөдөлгөөн засалч /Орхон аймгийн нэгдсэн эмнэлэг), Ишизаки Намико (сувилагч/Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг), Оомачи Юкико (компьютерийн мэргэжилтэн/Сэлэнгэ аймгийн МСҮТ), Кавахара Аяка (тогооч/Дундговь аймгийн МСҮТ), Нонами Рика (хөдөлмөр засалч/2-р эмнэлэг), Ёнэяма Ику (Хоол зүйч/Дархан-Уул аймгийн эрүүл мэндийн газар)

• ЖАЙКА-ын сайн дурын үйл ажиллагаа [Дэлхийн өдрийн тэмдэглэл]: Оно Юки (Нийгмийн ажилтан /Дорнод Их сургууль) → энд дар, Нацүми Адачи, залуу сайн дурын гишүүн (2016 оны 3 сар, /теннис/ Монголын талбайн теннисийн холбоо) → энд дар



ЖАЙКА-ийн сургалт төгсөгчдийн холбоо

Сургалт төгсөгч 5S-ийн семинар зохион байгууллаа



5S-ийн семинарын байдал

1 дүгээр сарын 22, 23-ны өдрүүдэд 2016 онд “5S-д суурилсан Япон маягийн менежмент сургалт”-нд хамрагдсан төгсөгч Б.Мөнхдэлгэр жижиг дунд бизнес эрхлэгч 100 гаруй эмэгтэйчүүдэд зориулан Монголын залуучуудын холбоон дээр 5S-ийн сургалт зохион байгууллаа. Жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулсан уг семинарын хүрээнд 5S үйл ажиллагаа гэж юу вэ? Япон улсын хөгжлийн нууц, 5S үйл ажиллагааг нэвтрүүлэн ажиллах боломж, давуу тал, үр дүнгийн талаар танилцуулж, сургалтаар дамжуулан олж авсан мэдлэг туршлагаа ашиглан байгууллагынхаа үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөөг хэрхэн боловсруулж хэрэгжүүлэх аргын талаар хэлэлцэн санал солилцлоо. Энэ удаагийн 5S-ийн сургалтаар төгсөгч маань ЖАЙКА-ийн 2 удаагийн сургалтаар олж авсан ноу-хау, мэдлэгээ олон хүнд түгээн дэлгэрүүлж чадсан төдийгүй жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн хэрэгцээ шаардлагыг хангасан ач холбогдолтой сургалт болсон юм.



独立行政法人 国際協力機構 モンゴル事務所

Bodi Tower 7th Floor, Sukhbaatar Square 3, Ulaanbaatar, Mongolia

(Central P.O.Box 682, Ulaanbaatar 211213, Mongolia)

Tel:+976-325939, 311329 Fax:+976-310845 E-mail: mg_oso_rep@jica.go.jp